



Н.МАНДАЛ

# Сайт ХҮҮХЭД





Надмидын МАНДАЛ

# Салхи ХУУХЭД



Улаанбаатар хот  
2007 он

“Сайн хүүхэд болох нууц”

**Н.МАНДАЛ**

## **Сайн хүүхэд**

“Сайн хүүхэд болох нууц” цуврал

Бага сургуулийн сурагчдад зориулав.

Зураач  
Хянан тохиолдуулагч  
Хянасан  
Дизайнер

Н.Батбадрах  
О.Мөнхтүяа  
Ж.Гэрэлмаа  
Т.Дэлгэрмаа

**INTERPRESS**

Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК


2007 он



Мөнхөө хүү энэ жил сургуульд орсон. Тэдний ангид олон цэнхэр ширээ байдаг юм. Хүүхдүүд хоёр хоёроороо зэрэгцэн суудаг. Нэг охин, нэг хүү. Голдуу тийм дээ. Харин Мөнхөө өөрийгөө азтайд тооцдог аж. Учир нь тэр ганц найз Баяраатайгаа нэг ширээнийх болжээ.



Чингэтэл ангид нь нэг охин шилжин ирснээс болж, тэд гуравлав. Мөнхөө Баяраа хоёр бие биенээ харан нүүрээ үрчийлгэн яrvайцаалаа. Шинэ сурагчид зайд бага гаргаж өгөх тухай нүдээрээ ярилцан тохирцгоов. Тэгээд ширээгээр нэг дэвтэр номоо тараан тохойгоо дэлгэн сууцгаажээ.



Охин юм хэлсэнгүй. Дэвтэр нь ширээний өнцөг дээр байсан ч дуугарсангүй. Хоёр хүү түүнийг хааяа өрөвдөвч бахь байдгаа өөрчилсөнгүй. "Яах гэж биднээс сүүлд ирсэн юм бэ!" хэмээн шүд зууцгаана. Багш охиныг муухай бичлээ гэх тоолонд тэд сэм баярлацааж байсныг нуух аргагүй.

“Сэйн түүхэд болс нийц”



Тэгж байтал нэг өдөр багш Баярааг өөр суудалд суулгах нь тэр ээ! Энэ шинэ ирэгчээс л боллоо гэдгийг мэдсэн Мэнхөө дотроо уурлав. Охиныг улам үзэн ядсан аж. Дэвтэр номоо урьд урьдхаасаа илүү тараан тавьдаг боллоо. Бүүр хэрэгцээгүй цааснуудыг хүртэл гаргаж тавив.

# Чи бүрдэг аж жарсааж бэлэнээвэл **САИН ХҮҮХЭД** боловшиг!

Ингээд хэдэн өдөр өнгөртөл ширээн дээр нь нэг юм гялсхийх шиг болжээ. Гялсхийнээр ч барагчуй, тэр нь дэлгээд тавьсан юм бичээгүй цаасан дээр нь үсрэн гарлаа. Мушигиранданхан цовхchoод л нэг л биш ээ! Явсан мөрөөр нь олон хар цэг үлдсэн байв. Хүү цэгүүдийг үзэгнийхээ хошуугаар холбоход эгчийнх нь дэвтрэн дээрх шиг юм нүдэнд нь харагдлаа. Бас өөрийнх нь сайн таньдаг болсон бичмэл “A” үсэг саргарын дунд хэд хэдээрээ байж байв аа.



Багш ирж нөгөө шинэ охиныг дахиад л “Муухай бичлээ” хэмээн загнав. “Ширээн дээр дэвтрээ гүйцэд тавьсангүй” гэж бас хэлэв. Мэнхөө муухай юм хийсэндээ гэмшивч Баяраатайгаа хамт суух хүсэл нь дийлсээр байжээ. Багшийг ширээнээс холдсоны дараа өнөө гялгар зүйл мэн л юм бичээгүй цаасан дээр нь хорсолтойгоор дэвхцэж эхэллээ. Мэнхөөгийн үзэг хойноос нь дагав.

# Чи бүрдэг аж жарсааж бэлэнээвэл **САИН ХҮҮХЭД** боловшийн!

Гялгар заавал Мөнхөөгийн цааснууд дээр дэвхцээд байхдаа яахав дээ?! Хоёр хелөө салгахгүй дэвхцэх нь юутай ч адил юм бэ дээ? Ямар нэгэн “Хорлогч” байж магадгүй гэж санаад Мөнхөө битүүхэндээ айсан нь лавтай. Тэгтэл бас эртүүдхэн үзсэн Э, У, О үсгүүд байж нь юу вэ? Энэ саргар аягүй бол нэг муухай үг бүтээсэн байгаа даа!



Нэг шене Мэнхөө звгүй зүүд зүүдлэв. Гялгарын үлдээсэн мөрүүд үг болон амилж гэнэ. "Чи бол энэ дэлхийн хамгийн муу хүүхэд" гэсэн үг байхыг үсгээ гүйцэд таниагүй хэрнээ хүү уншив. Уншиж дуусмагц нь "Үг" түүнийг хөөж эхэлжээ. Мэнхөө зугтаагаад л байлаа. Муухай үг янз бүрийн араатны дүрсэд ороод хувилаад л байсан. Сэргээгүй бол яах ч байсан юм билээ! Одоо л...



Тэгэвч хүү дэвтэр номоо тараасан хэвээр. Сандлаа бас нэг ч удаа татахгүй байлаа. Охины хувьд хэчинээн хэцүү ч тэвчээртэй гэж хачин. Тэр багшийг харах үед л ширээ рүү дэвтрээ жаахан түлхэнэ. Бусад үед тэруүхэн тэндээ бичгээ ч бичиж, номоо ч унших ажээ. Ширээн дээр эрээ цээргүй гүй Гялгарыг харах ч үгүй байх нь бүр ч хачирхалтай.



Өдөр хоног өнгөрөх тусам саргар зам гаргасан өнөө цэгэн мөрүүдэд таньдаг үсэг олшиирсоор байлаа. Мөнхөө тэгэх тусам нь эл үг хэнд хандсан, юу гэсэн болохыг мэдэхийг хүсчээ. Зүүдэнд орсон үг байх гэж санахаас аиж байв. Аих тусмаа муу хүүхэд болохгүй тулд хичээлээ улам бүр сайн хийгээд байлаа. Сайн сурах нь “Сайн” хүүхдийн шинж биш гэж үү?

# Чи бүрдэг аж жарсааж бэлээжээл **САИН ХҮҮХЭД** боловшиг!

Тэгж байтал Мөнхөөгийн хажууд суудаг охин өвдөөд хичээлдээ ирсэнгүй. Эмээ нь ирж уулзжээ. Хэдэн өдрийн чөлөө авсан гэж хэлсэн нь мэдээж. Түүнийг сонсоод Баяраагийн баярлаж байна гэдэг жигтэйхэн. Шууд л цүнхээ тэвэрсээр хуучин суудалдаа ирж суув. Гурван өдөр хоёр найз нэг ширээнд тохой нийлүүлэн сууж чамгүй баяртай байлаа. Охиныг дагаад Гялгар ч үзэгдсэнгүй. Харин Мөнхөөгийн өмнө байх саргар бичигтэй цаасыг Баяраа олж харжээ.

# Чи бусдаа аж жаралыг бэлэглэвэл **САИН ХҮҮХЭД** бамно шинж!

Тэр хоёр түүнийг унших гэж оролдов. Тэгээд ЧИ гэж байна хэмээн хоёул зэрэг хашхирлаа. ЧИ-гийн удаагаар БУСДАД хэмээх үгийг үсэглэн гаргаж ирэв. А-А-А-З, АЗ, Ж-А ЖА, Р ЖА-Р ЖАР, Г-А ГА, ЖАР-ГА ЖАРГА, Л ЖАРГАЛ, ЧИ БУСДАД АЗ ЖАРГАЛ... Хоёр найз цаасан дээрх бичээсийг үсэглэн, үелэн, нийлүүлэн уншсаар байв.

# Чи бусдад аз жаргалыг бэлэглэвэл **САИН ХҮҮХЭД** болж ширу!

Тэгээд: Уг үгнүүд ЧИ БУСДАД АЗ ЖАРГАЛЫГ  
БЭЛЭГЛЭВЭЛ САИН ХҮҮХЭД БОЛНО ШҮҮ гэсэн  
өгүүлбэр болохыг сая гаргаад инээмсэглэлээ.  
Өөдөр өөдөөсөө хараад инээмсэглэв.  
Маргааш нь Мэнхөөгийн хажуугийн охин  
хичээлдээ ирсэн юм. Мэнхөө дэвтэр номоо  
цүнхнээсээ цэгтэйхэн гаргаж тавиад охин руу  
хараад инээмсэглэв. Ширээний анд нь бас хариу  
инээмсэглэж байна.



Хүүгийн зэж нэг удаа "Хүн аз жаргалтай байхдаа л инээмсэглэдэг" гэж хэлж байсан билээ.

Мөнхөө гэр лүүгээ гүйж явахдаа

- Би сайн хүүхэд! хэмээн амандaa шивнэж явав. Тийм ээ, тэр хүү Гялгарын бичсэн үгийг олон дахин хуулж, тунгаасаар байгаад "Сайн" хүүхэд болсон билээ. Чи ч гэсэн бас Гялгарын мөрнүүдийг үзгээрээ дагуулаад байсан бол "Сайн" хүүхэд мөнөөсөө мөн шүү дээ!



# ХУЧХӨҮҮД ЭЭ!

Номоо уншаад,  
ялангуяаын явсан мөрийн  
үзүүлэхээ тодруулан  
дагаадай. Номынхoo  
зүрхийн будан  
йимэилэхээ  
мафтав аа!



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй  
«Хөдөөгийн боловсролыг дэмжих  
(READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.  
Худалдахыг хориглоно.